

**Барилга байгууламжийн зураг төсөлд магадлал хийх экспертэд
тавих шаардлага, түүнийг өрсөлдөөний журмаар сонгон
шалгаруулж, эрх олгох журам¹**

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Барилга байгууламжийн зураг төсөлд магадлал хийх иргэн, хуулийн этгээдэд тавих шаардлага, сонгон шалгаруулах, экспертийн эрх олгох үйл ажиллагааг зохион байгуулах, түүнд хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2. Барилга байгууламжийн зураг төсөлд магадлал хийх иргэн, хуулийн этгээдийг өрсөлдөөний журмаар сонгон шалгаруулахад шударга, ил тод, эрх тэгш хандах болон нээлттэй өрсөлдөөний зарчмыг удирдлага болгоно.

1.3. Барилгын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.2, 25.3, 25.5, 25.8 дахь заалтад заасан барилга байгууламжийн зураг төсөлд магадлал хийх эрх авсан иргэн, хуулийн этгээд нь “Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, магадлал хийх дүрэм”-ийн 5, 6 дугаар зүйлд заасныг баримтлан магадлал хийнэ.

1.4. Барилга байгууламжийн зураг төсөлд магадлал хийх иргэн, хуулийн этгээдийг сонгон шалгаруулж, экспертийн эрх олгох үйл ажиллагааг эрх бүхий этгээдийн шийдвэр эсхүл Барилгын тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2, 36 дугаар зүйлийн 36.1 дэх заалтад заасан чиг үүргийн хэрэгжүүлэгч байгууллага /цаашид “зохион байгуулагч” гэх/ эрхлэн хэрэгжүүлнэ.

1.5. Барилга байгууламжийн зураг төсөлд магадлал хийх иргэн, хуулийн этгээдийг сонгон шалгаруулж, экспертийн эрх олгох үйл ажиллагааг зохион байгуулагч байгууллага цахимаар зохион байгуулна

1.6. Барилга байгууламжийн зураг төсөлд магадлал хийх иргэн, хуулийн этгээд нь тухайн зураг төсөл боловсруулагчтай ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдэл, тайлбарыг зохион байгуулагчид гаргаж өгнө.

1.7. Барилга байгууламжийн зураг төсөлд магадлал хийх эрх авсан иргэн, хуулийн этгээдийн сонгон шалгаруулалт, бүртгэлийн мэдээллийг олон нийтэд нээлттэй ил тод зохион байгуулж, мэдээлэх ба зохион байгуулагч бусдад давуу эрх олгохоос зайлсхийж татгалзах үүрэгтэй.

Хоёр. Магадлал хийхэд баримтлах зарчим

2.1. Магадлал хийх иргэн, хуулийн этгээд нь Барилгын тухай хууль болон “Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, магадлал хийх дүрэм”, норм, нормативын баримт бичгийг мөрдөж ажиллахаас гадна дор дурдсан зарчмыг баримтална.

¹ Барилгын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.3 дахь заалт

2.1.1. мэргэжлийн ёс зүйг чанд баримтлах;

2.1.2. ашиг сонирхлоос ангид байх, бусдын нөлөөнд үл автах;

2.1.3. магадлал хийх иргэн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд хөндлөнгөөс оролцохгүй байх.

2.2. Барилга байгууламжийн зураг төслийн дараах чиглэл тус бүрээр экспертийн эрх олгоно.

2.2.1. Хот төлөвлөлтийн зураг төсөл;

2.2.2. Барилга, архитектур /эзлэхүүн/ төлөвлөлтийн зураг төсөл;

2.2.3. Ландшафт;

2.2.4. Барилга байгууламжийн инженер-геологи, геобухникийн судалгаа, зураг төсөл;

2.2.5. Барилга байгууламжийн бүтээцийн зураг төсөл;

2.2.6. Дулаан хангамж, агаар сэлгэлтийн системийн зураг төсөл;

2.2.7. Барилга байгууламжийн цахилгаан хангамжийн системийн зураг төсөл;

2.2.8. Ус хангамж, ариутгах татуургын системийн зураг төсөл;

2.2.9. Барилга байгууламжийн мэдээлэл, холбоо дохиоллын системийн зураг төсөл;

2.2.10. Барилга байгууламжийн автоматжуулалтын системийн зураг төсөл;

2.2.11. Барилга байгууламжийн галын аюулгүй байдлын техник, тоноглолын зураг төсөл;

2.2.12. Газрын тос, газрын тосны бүтээгдэхүүн, хий хангамжийн барилга байгууламжийн зураг төсөл;

2.2.13. Усны барилга байгууламжийн зураг төсөл;

2.2.14. Хөргөх байгууламжийн технологийн тоног төхөөрөмжийн зураг төсөл;

2.2.15. Геодезийн хэмжилт, зураглал;

2.2.16. Агаарын зураглал боловсруулалт;

2.2.17. Зураг зүй;

2.2.18. Хот төлөвлөлтийн эдийн засагч;

2.2.19. Барилга байгууламжийн угсралт, засварын ажлын төсөв;

2.2.20. Эрчим хүчний барилга байгууламжийн угсралт, засварын ажлын төсөв;

2.2.21. Ус, дулаан хангамж, ариутгах татуургын шугам, сүлжээний угсралт, засварын ажлын төсөв;

2.2.22. Барилга байгууламжийн мэдээлэл, холбоо, дохиоллын системийн угсралт, засварын ажлын төсөв;

2.2.23. Газрын тос, газрын тосны бүтээгдэхүүн, хий хангамжийн барилга байгууламжийн угсралт, засварын ажлын төсөв;

2.2.24. Усны барилга байгууламжийн угсралт, засварын ажлын төсөв.

Гурав. Магадлал хийх иргэн, хуулийн этгээдэд тавих шаардлага

3.1. Барилга байгууламжийн зураг төсөлд магадлал хийх иргэн, хуулийн этгээдийг магадлал хийх эрх олгох сонгон шалгаруулалтад энэ журмын 3.2, 3.3-т заасан шаардлагыг хангасан зөвхөн тухайн чиглэлийн зураг төслийн мэргэшлийн зэрэгтэй иргэн, хуулийн этгээд оролцоно.

3.2. Магадлал хийх иргэн нь дараах шаардлагыг хангасан байна.

3.2.1. Барилгын салбарын архитектор, инженерийн мэргэжлээр дээд боловсрол эзэмшсэн байх;

3.2.2. Барилгын тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.3.3-д зааснаар зураг төслийн хүрээний мэргэшлийн зэрэгтэй байх;

3.2.3. Тухайн мэргэжлийн чиглэлээр зураг төсөл боловсруулах эрх бүхий аж ахуйн нэгж, байгууллагад 15-аас доошгүй жил ажилласан байх;

3.2.4. дунд төвөгшилтэй болон түүнээс дээш төвөгшилтэй барилга байгууламжийн 40-оос доошгүй зураг төсөл боловсруулсан байх;

3.2.5. Мэргэжлийн чиглэлийн 3-аас доошгүй барилгын норм, нормативын баримт бичиг, стандарт боловсруулсан, боловсруулахад хамтран оролцсон эсхүл редакц, шүүмж хийсэн, эрдэм шинжилгээ, судалгааны бүтээл туурвисан байх;

3.2.6. Барилгын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3-д заасны дагуу мэргэжлийн хариуцлагын даатгалд даатгуулсан байх;

3.2.7. Комьютерын хэрэглээний болон зураг төсөл, тооцооллын программыг ашиглах чадвартай байх.

3.3. Магадлал хийх хуулийн этгээд нь дараах шаардлагыг хангасан байна.

3.3.1. Магадлал хийх хуулийн этгээд нь Монгол Улсад бүртгэлтэй байх;

3.3.2. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага хангасан ажлын байр /ажлын болон уулзалтын өрөө, архив, норм, нормативын баримт бичиг бүхий номын сан, тоног төхөөрөмж/-тай байх;

3.3.3. Энэ журмын 2.2-т заасан чиглэл тус бүрээр магадлал хийх эрх бүхий 2-оос доошгүй эксперттэй байх;

3.3.4. Магадлал хийх эрх авсан эксперт тус бүртэй хөдөлмөрийн гэрээ байгуулсан байх;

3.3.5. Магадлал хийх ажлыг хариуцан зохион байгуулах, удирдах туршлагатай 2-оос доошгүй орон тооны ажилтантай байх;

3.3.6. “Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, магадлал хийх дүрэм”-ийн 5 дугаар зүйлд заасан нөхцөлийг бүрдүүлсэн байх;

3.3.7. Хараат бус бие даасан байдлыг хамгаалах хариуцлагын тогтолцоо бүрдүүлсэн байх;

3.3.8. Хуулийн этгээдийн хариуцлагын даатгал хийлгэсэн байх.

3.4. Магадлал хийх хуулийн этгээд нь иж бүрэн зураг төсөлд магадлал хийнэ.

Дөрөв. Магадлал хийх иргэн, хуулийн этгээдийг сонгон шалгаруулалтыг зохион байгуулах

4.1. Барилга байгууламжийн зураг төсөлд магадлал хийх иргэн, хуулийн этгээдийг сонгон шалгаруулж экспертийн эрх олгох үйл ажиллагааг энэ журмын 1.4-т заасан зохион байгуулагч байгууллагаас томилсон ажлын хэсэг /цаашид “Ажлын хэсэг” гэх/ сонгон шалгаруулна.

4.2. Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд барилга байгууламжийн зураг төслийн талаар мэдлэг, туршлагатай эрдэмтэн, судлаач, мэргэжилтний төлөөлөл, барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын тухайн асуудал хариуцсан мэргэжилтэн, салбарын холбогдох мэргэжлийн байгууллага, шударга, өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газрын төлөөллийг оролцуулах ба 9-өөс доошгүй гишүүний бүрэлдэхүүнтэй байна.

4.3. Ажлын хэсгийн гишүүд нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх заалт, 14 дүгээр зүйлийн шаардлагыг биелүүлсэн байх.

4.4. Ажлын хэсгийн дарга нь зохион байгуулагч байгууллагын магадлалын асуудал эрхэлсэн нэгжийн дарга байна.

4.5. Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга нь зохион байгуулагч байгууллагын магадлалын асуудал эрхэлсэн нэгжийн мэргэжилтэн байх бөгөөд дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

4.5.1. Ажлын хэсгийн хурлын бэлтгэлийг хангах, зохион байгуулах, хурлын товыг зарлан ирцийг бүрдүүлэх;

4.5.2. Сонгон шалгаруулалтад ирүүлсэн материалуудын бүртгэлийг хөтлөх, тавигдах шаардлагын дагуу тулган нэгтгэж ажлын хэсэгт танилцуулах;

4.5.3. Ажлын хэсгийн хурлын тэмдэглэл хөтөлж, хурлын шийдвэрийг зохих журмын дагуу албажуулах;

4.5.4. Сонгон шалгаруулалтад ирүүлсэн материалыг хурлын шийдвэрийн хамт зохих журмын дагуу архивд шилжүүлэх.

4.6. Ажлын хэсэг дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

4.6.1. Магадлал хийх эрх горилогч иргэний холбогдох материалыг энэ журмын 5.3.1, 5.3.2-т заасан шаардлагад нийцсэн эсэхийг тулгана.

4.6.2. Сонгон шалгаруулалтад ирүүлсэн иргэн, хуулийн этгээдийн материалуудыг судалж, энэ журмын 3.2, 3.3-т заасан шаардлага хангасан тохиолдолд эрх олгох шийдвэр гаргана.

4.6.3. Сонгон шалгаруулалттай холбоотой аливаа асуудлыг хурлаараа хэлэлцэн олонхын саналаар шийдвэрлэнэ.

4.6.4. Сонгон шалгаруулалтын дүнг ажлын хэсгийн хурлаар хэлэлцэн зохих шийдвэр гаргана. Хурлын шийдвэрийг 2 хувь үйлдэж ажлын хэсгийн дарга, гишүүд гарын үсэг зурна.

4.6.5. Магадлал хийх иргэн, хуулийн этгээдийг сонгон шалгаруулах үйл ажиллагааг ил тод, өрсөлдөх тэгш боломжтой байх зарчмыг баримтлах бөгөөд чадварыг үнэлэх байдлыг харгалзан дүгнэнэ.

4.7. Барилга байгууламжийн зураг төсөлд магадлал хийх иргэн, хуулийн этгээдийг сонгон шалгаруулах үйл ажиллагааг материал хүлээн авах хугацаа дууссанаас хойш хуанлийн 14 хоногт багтаан зохион байгуулах.

4.8. Сонгон шалгаруулалт зохион байгуулах тухай бүрд ажлын хэсгийг шинээр байгуулна.

4.9. Ажлын хэсгийн дүгнэлтийг зохион байгуулагч байгууллагын дарга баталгаажуулна.

4.10. Ажлын хэсгийн дүгнэлтэд иргэн, хуулийн этгээдэд эрх олгох боломжгүй талаарх үндэслэлийг тодорхой тусгасан байна.

4.11. Энэ журмаар тогтоосон сонгон шалгаруулалтаар шаардлага хангаагүй иргэн, хуулийн этгээдэд ажлын хэсгийн дүгнэлтийг үндэслэн хариуг ирүүлсэн материалын хамт албан бичгээр хүргүүлнэ.

4.12. Барилга байгууламжийн зураг төсөлд магадлал хийх экспертийн сонгон шалгаруулалтыг жилд 1-ээс доошгүй удаа зохион байгуулна.

Тав. Сонгон шалгаруулалтыг мэдээлэх, оролцогчдыг бүртгэх

5.1. Ажлын хэсэг нь сонгон шалгаруулалтын мэдээллийг 21-ээс доошгүй хоногийн өмнө хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлнэ. Иргэн, хуулийн этгээдийн сонгон шалгаруулалтыг тус тусад нь зарлаж, шалгаруулна.

5.2. Сонгон шалгаруулалтын мэдээлэлд энэ журмын 3 дугаар зүйлд заасан тавих шаардлага, 5.3.1, 5.3.2-т заасан бүрдүүлэх материал, материал хүлээн авах, сонгон шалгаруулалт хийх ажлын хэсгийн хаяг, байршил харилцах утасны дугаар, хугацаа зэргийг тодорхой заана. Мэдээлэлд өөрчлөлт оруулах зайлшгүй шаардлага гарсан тохиолдолд ажлын хэсэг тухай бүрд мэдээлж байна.

5.3. Магадлал хийх эрх горилох иргэн, хуулийн этгээдийн хүсэлтэд энэ журмын 3.2, 3.3-д заасан шаардлагыг хангаж буйг нотлох баримтаас гадна энэ журмын 5.3.1, 5.3.2-т заасан баримт бичгийг бүрдүүлсэн байна.

5.3.1. Магадлал хийх эрх горилогч иргэн дараах баримт бичгийг бүрдүүлсэн байна. Үүнд:

5.3.1.1. Төрийн албан хаагчийн анкет /ТАХ№1 маягтын дагуу/

5.3.1.2. Иргэний үнэмлэхийн лавлагаа;

5.3.1.3. Мэргэжлийн боловсролын гэрчилгээ, дипломын хуулбар;

5.3.1.4. Нийгмийн даатгалын лавлагаа;

5.3.1.5. Мэргэшлийн зэргийн гэрчилгээний хуулбар;

5.3.1.6. Өөрийн мэргэжлийн чиглэлээр бие даан гүйцэтгэсэн ажлын жагсаалт, холбогдох хэсгийн магадлалын дүгнэлтийн архивын хуулбарын хамт ирүүлэх;

5.3.1.7. Мэргэжлийн хариуцлагын даатгалын гэрээ.

5.3.2. Магадлал хийх эрх горилогч хуулийн этгээд дараах баримт бичгийг бүрдүүлсэн байна. Үүнд:

5.3.2.1. Хуулийн этгээдийн мэдээлэл (Улсын бүртгэлийн гэрчилгээг мэдээллийн цахим системээс шалгана);

5.3.2.2. Хуулийн этгээдийн танилцуулга;

5.3.2.3. Магадлал хийх багийн бүрэлдэхүүний жагсаалт; /овог нэр, регистрийн дугаар, мэргэжлийн боловсролын гэрчилгээ, мэргэшлийн зэргийн гэрчилгээний хуулбар/;

5.3.2.4. Энэ журмын 3.3.3-т заасан орон тооны ажилтнуудын хөдөлмөрийн гэрээ;

5.3.2.5. Хуулийн этгээдийн сүүлийн 1 жилийн нийгмийн даатгал төлөлтийн лавлагаа;

5.3.2.6. Шаардлагатай бол зохих чиглэл, хүрээний дагуу магадлал хийсэн зураг төсөл, хийж гүйцэтгэсэн танилцуулга, бусад нотлох баримт /магадлалын дүгнэлт/.

Зургаа. Барилга байгууламжийн зураг төсөлд магадлал хийх иргэн, хуулийн этгээдэд эрх олгох

6.1. Ажлын хэсгийн дүгнэлтийг үндэслэн зохион байгуулагч байгууллагын дарга тушаал гаргаж иргэн, хуулийн этгээдэд барилга байгууламжийн зураг төслийн тухайн чиглэлд магадлал хийх эрхийг 3 жилийн хугацаатай олгоно.

6.2. Энэ журмын 6.1-д заасан экспертийн эрх авсан иргэн, хуулийн этгээдэд олгох дардасны загварыг Барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.

6.3. Магадлал хийх эрх бүхий иргэн нь энэ журмын 3.2-т заасан шаардлагыг хангасан 2-оос дээшгүй хуулийн этгээдтэй гэрээ байгуулан ажиллаж болно.

6.4. Зохион байгуулагч байгууллагын тушаалаар экспертийн эрх авсан иргэн, хуулийн этгээдэд барилга байгууламжийн зураг төсөлд магадлал хийснийг баталгаажуулах дардсыг олгоно.

6.5. Энэ журмын 6.1-д заасан шийдвэрийг үндэслэн зохион байгуулагч байгууллага магадлал хийх иргэн, хуулийн этгээдтэй гэрээ байгуулж, жил бүр дүгнэнэ.

6.6. Магадлал хийх эрх бүхий хуулийн этгээд нь зохион байгуулагч байгууллагад гэрээний дагуу гүйцэтгэсэн ажлаа улирал тутамд тайлагнана.

6.7. Магадлал хийх эрх бүхий хуулийн этгээд нь магадлалын дүгнэлт гарч албажсан тухай бүрд цахим системд олон нийтэд нээлттэй байршуулна.

6.8. Барилга байгууламжийн зураг төсөлд хийгдсэн магадлалын үйл ажиллагааны бүртгэл, мэдээллийн санг зохион байгуулагч байгууллага хөтлөх

бөгөөд холбогдох тайлан, мэдээг барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад улирал бүр тайлагнана.

Долоо. Магадлал хийх эрх бүхий иргэн, хуулийн этгээдийн эрхийг цуцлах

7.1. Магадлал хийх эрхтэй иргэний эрхийг зохион байгуулагч байгууллагын даргын тушаалаар дараах тохиолдолд цуцална:

7.1.1. иргэн өөрөө хүсэлт гаргасан;

7.1.2. экспертийн тэмдэг болон мэдээллийн санд нэвтрэх эрхийг бусдад ашиглуулсан;

7.1.3. Барилга байгууламжийн зураг төслийн техникийн шийдэл болон техник, эдийн засгийн үндэслэл, төсөвт өртгийн тооцооллыг хүчин төгөлдөр мөрдөгдөж буй норм, нормативын баримт бичигт үндэслээгүй, судалгаагүй дүгнэлт гаргаж, мэргэжлийн болон техникийн шийдлийн ноцтой зөрчил гаргасан нь барилгын улсын хяналт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллагаас тогтоогдсон;

7.1.4. магадлал хийхдээ хувийн эрх ашгаар хандаж, ашиг сонирхлын зөрчил үүссэн нь эрх бүхий байгууллагаас тогтоогдсон;

7.1.5. өөрийн болон хамаарал бүхий этгээдийн зураг төсөлд магадлал хийсэн;

7.1.6. Монгол Улсын хууль тогтоомж болон зохион байгуулагч байгууллагатай байгуулсан барилга байгууламжийн зураг төсөлд магадлал хийх гэрээний заалтуудыг зөрчсөн;

7.1.7. ёс зүйн харилцааны доголдол гаргасан нь баримтаар нотлогдсон;

7.1.8. экспертийн эрх олгогдсоноос хойш нэг жилийн хугацаанд магадлал хийгээгүй;

7.1.9. Энэ журмын 6.5-д заасан гэрээний хугацаа дууссан.

7.2. Магадлал хийх эрхтэй хуулийн этгээдийн эрхийг зохион байгуулах байгууллагын даргын тушаалаар дараах тохиолдолд цуцална:

7.2.1. барилга байгууламжийн зураг төсөлд магадлал хийх үйл ажиллагаанаасаа татгалзсан;

7.2.2. тайлан мэдээ 2 улирал дараалан өгөөгүй;

7.2.3. магадлалын үйл ажиллагааг нэг жил эрхлээгүй;

7.2.4. хуулийн этгээд өөрчлөн байгуулагдсан, дампуурсан, татан буугдсан болон хууль тогтоомжид заасан үндэслэлээр үйл ажиллагаа нь дуусгавар болсон;

7.2.5. өөрийн болон хамаарал бүхий этгээдийн зураг төсөлд магадлал хийсэн;

7.2.6. Монгол Улсын хууль тогтоомж болон зохион байгуулагч байгууллагатай байгуулсан барилга байгууламжийн зураг төсөлд магадлал хийх гэрээний заалтуудыг зөрчсөн;

7.2.7. анх эрх авах үеийн гишүүдийн гуравны нэгээс доошгүй хувь нь хуулийн этгээдийн бүрэлдэхүүнээс гарсан;

7.2.8. Барилга байгууламжийн зураг төслийн техникийн шийдэл болон техник, эдийн засгийн үндэслэл, төсөвт өртгийн тооцооллыг хүчин төгөлдөр мөрдөгдөж буй норм, нормативын баримт бичигт үндэслээгүй мэргэжлийн болон техникийн шийдлийн ноцтой зөрчил бүхий дүгнэлт гаргасан нь барилгын улсын хяналт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллагаас тогтоогдсон.

7.2.9. Энэ журмын 6.5-д заасан гэрээний хугацаа дууссан.

Найм. Магадлал хийх эрх авсан иргэн, хуулийн этгээдийн эрх, үүрэг

8.1. Барилга байгууламжийн зураг төсөлд магадлал хийх иргэн, хуулийн этгээдийг сонгон шалгаруулахтай холбогдсон асуудлаар гаргасан маргааныг хууль тогтоомжид заасны дагуу шийдвэрлэнэ.

8.2. Барилга байгууламжийн зураг төсөлд магадлал хийх иргэн, хуулийн этгээд нь хамаарал бүхий этгээдийн зураг төсөлд магадлал хийхээс татгалзах үүрэгтэй.

8.3. Барилга байгууламжийн зураг төсөлд магадлал хийх иргэн, хуулийн этгээдийг сонгон шалгаруулж, экспертийн эрх олгох үйл ажиллагааг зохион байгуулагч байгууллага нь магадлал хийх эрх бүхий иргэн, хуулийн этгээдийн бүртгэлтэй холбоотой санал, гомдлыг цахим системд байршуулж, хуульд заасны дагуу шийдвэрлэх, бүртгэлийн талаар цахим хуудсаар болон бусад хэлбэрээр нийтэд мэдээлэх, эрх бүхий байгууллагад тайлагнах ажлыг зохион байгуулж хэрэгжүүлнэ.

8.4. Барилга байгууламжийн зураг төсөлд магадлал хийлгэх зураг төслийн байгууллага нь хууль, тогтоомж, норм, норматив, стандартыг зөрчих, илт хууль бус шаардлагыг биелүүлэхийг шаардах, дарамтлах, үйл ажиллагааг хясан боогдуулах зэрэг үйлдлийг магадлал хийх эрх бүхий иргэн, хуулийн этгээдэд тавихыг хориглох бөгөөд магадлал хийхээс татгалзах эрхтэй.

8.5. Барилга байгууламжийн зураг төсөлд магадлал хийх эрх бүхий иргэн, хуулийн этгээд нь тухайн зураг төсөлд магадлал хийхдээ норм, нормативын баримт бичгийг ноцтой зөрчсөнийг барилга байгууламжийн техникийн улсын хяналт хэрэгжүүлэх байгууллагын тогтоосноор гуравдагч этгээд /хөрөнгө оруулагч/-д учруулсан хохирлыг Эрүүгийн болон Зөрчлийн тухай хуулиар хариуцлага хүлээснээс үл хамааран төлж барагдуулна.

8.6. Барилга байгууламжийн зураг төсөлд магадлал хийх эрх бүхий иргэн, хуулийн этгээд нь барилга байгууламжийг норм, норматив, стандарт болон мэргэжлийн ёс зүйн алдаа гаргасныг барилга байгууламжийн техникийн улсын хяналт хэрэгжүүлэх байгууллага тогтоосон бол магадлал хийх эрх болон мэргэшлийн зэргийг таван жилээр цуцалж, Зөрчлийн тухай хуулийн хариуцлага хүлээнэ.

8.7. Барилга байгууламжийн зураг төсөлд магадлал хийх эрх бүхий иргэн нь санаатай болон санамсаргүй үйл ажиллагааны улмаас гаргасан алдаа, учруулсан хохирлыг барилга байгууламжийн техникийн улсын хяналт хэрэгжүүлэх байгууллага тогтоосон тохиолдолд энэ журмын 8.6 дахь заалтын дагуу хариуцлага тооцож, магадлал хийх эрх олгохоос татгалзана.

8.8. Барилга байгууламжийн зураг төсөлд магадлал хийх эрх бүхий хуулийн этгээдийн мэргэжилтнүүд санаатай болон санамсаргүй үйл ажиллагааны улмаас гаргасан алдаа, учруулсан хохирлыг барилга байгууламжийн техникийн улсын хяналт хэрэгжүүлэх байгууллага тогтоосон тохиолдолд магадлал хийсэн хуулийн этгээдэд 8.6 дахь заалтын дагуу хариуцлага тооцож, магадлал хийх эрх олгохоос татгалзана.

8.9. Магадлал хийх экспертийн эрх бүхий иргэн нь тухайн зураг төслийн өөрт холбогдох хэсгийн магадлалын дүгнэлтэд, хуулийн этгээд нь иж бүрэн зураг төслийн магадлалын дүгнэлтэд мэргэжлийн хариуцлага хүлээнэ.

---o0o---